

УДК 398.22 + 821.581

DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-231-264

Традиция и трансформация монгольской версии «Истории Арджи Бурджи-хана»

*Цагаан*¹

¹ Синьцзянский государственный университет (д. 14, ул. Шенгли, 830046 Урумчи, СУАР, КНР)
доктор филологических наук, доцент
E-mail: Chaha@163.com

© КалмНЦ РАН, 2020

© Цагаан, 2020

Аннотация. На монгольском языке известны три текста, в которых повествуется история жизни царя Бигармиджиды, — «История Бигармиджид-хана», «История Арджи Бурджи-хан» и «История Гесне-хана». Трилогия связана единым сюжетом, построена на основе рассказов тридцати двух деревянных человечков волшебного царского трона. Считается, что эта трилогия происходит из Индии, но нет никаких данных о том, была ли она передана в устной или письменной форме, кем и когда она была переведена. В данной статье дается сравнительный анализ монгольских (монгольской, бурятской и калмыцкой) версий «Истории Арджи Бурджи-хана».

Ключевые слова: «История Арджи Бурджи-хана», триада, монгольская версия, бурятские сказки «Арджи Бурджи-хан» версия, калмыцкие сказки «Арджи Бурджи-хан»

Благодарность. Исследование выполнено при финансовой поддержке Академии общественных наук Китая в рамках научного проекта № 14СМЗ015 «Фольклор калмыков: сюжетный указатель сказок». Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Цагаан. Традиция и трансформация монгольской версии «Истории Арджи Бурджи-хана» // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 4. С. 231–264. (На монг.) DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-231-264

UDC 398.22 + 821.581

DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-231-264

The Tradition and Transformation of the Mongolian Version of “The History of Arji Burji Khan”

*Chahan*¹

¹ Xinjiang State University (14, Shengli Road, Urumqi, Xinjiang 830046, China)

Ph.D. (Pilology), Associate Professor

E-mail: Chaha@163.com

© KalmSC RAS, 2020

© Chahan, 2020

Abstract. There are three texts in the Mongolian language which tell the story of the life of King Bigarmidzhid — “History of Bigarmijid Khan”, “History of Arji Burji Khan” and “History of Gesne Khan”. The trilogy connected by a single plot is built on the basis of the stories of thirty-two wooden men of the magical royal throne. It is believed that the trilogy originated in India, but there are no records on whether it was transmitted orally or in writing and on who and when translated it. This article gives a comparative analysis of the Mongolian (Mongolian, Buryat and Kalmyk) versions of the “History of Arji Burji Khan”.

Keywords: “History of Arji Burji-khan”, triad, Mongolian version, Buryat tales “Arji Burji-khan”, Kalmyk tales “Arji Burji-khan”

Acknowledgement. The research was funded by the Academy of the Social Studies of China under the scope of the research project № 14CMZ015 “Folklore of the Kalmyks: a subject index of fairy tales”. The article was

presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Chahan. The Tradition and Transformation of the Mongolian Version of the “History of Arji Burji Khan”. In: *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 4. Pp. 231–264. (In Mong.) DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-231-264

I. Монгол “Арж Борж хааны намтар”-ыг эмхтгэж хэвлэж судласан байдал

Монгол хэлээр “Бигэрмижэд хааны намтар”, “Арж Борж хааны намтар”, “Гэсэнэ хааны намтар” хэмээх гурван гар бичмэл зохиол байдаг. Энэ гурван номд Бигэрмижэд хааны явдал, түүний эрдэний ширээн дэхь гучин хоёр модон хүний өгүүлсэн үлгэрүүд гарах тул энэ гурвуулыг нэг хэлхээ зохиол гэж нэрлэдэг юм байна. Энэ гурван зохиолыг Энэтхэг гаралтай зохиол гэдэг боловч эдгээр зохиолууд нь Энэтхэгийн ямар номоос орчуулагдсан?, мөн түүнчлэн амаар уламжлагдсан юм уу?, бичгээр уламжлагдсан юм уу?, гэдгийн тухай тодорхой түүх сураг чимээгүй мөрдөх эрдэмтдийн үзэлтээс адил бус байх жишээтэй. Энэ тухай монгол судлалын нэрт эрдэмтэн академич Ц. Дамдинсүрэнгээс “Энэтхэг ардын уран зохиолын түүх судлалыг үзэхэд\ гучин хоёр модон хүний үлгэр\ Арж Борж хааны намтар\ гэдэг ном байдаг боловч \ Бигэрмижэд хааны цэцэг хатнаа авсан намтар\, Гэсэнэ хааны намтар\ гэдэг ном байдаггүй бололтой юм. Эдгээр гурван зохиолыг төвд хэлнээс орчуулсан болов уу гэхэд эдгээрийн төвд хэл дээрх хуучин эх зохиол огт үзэгдэхгүй бөгөөд харин монгол хэлнээс төвд хэл рүү орчуулсан гурван намтар монгол улсын номын санд хадгалагдаж байна” [Дамдинсүрэн, Чанту 1983: 586] гэж тодорхойлсноос үзэхэд Энэтхэгийн Бигэрмижэд хааны үйл явдалтай холбоотой цуврал олон үлгэр домогууд англи эхдээ монголд амаар уламжлагдаж, монголчуудын оюун ухаанаар дамжин дахин боловсруулагдаж, монгол бичигт тэмдэглэгдсэний дараагаар төвд хэлд орчуулагдсан

байж болох талтай. “Бигэрмижэд хааны намтар”-ын тухай академич Ц. Дамдинсүрэн судалсны үр дүндээ: “Вигэрмадита гэдэг нэгэн шударга хаан одоогоос хоёр мянган жилийн өмнө Энэтхэг оронд байсан гэдэг боловч түүний намтар түүх тодорхойгүй, үлгэр домогийн чанартай үг өгүүлэл байдаг байна”. Монголын “Бигэрмижэд хааны намтар”-ыг Энэтхэгийн Вигэрмадита хаантай холбоотой болов уу гэдэг байна. “Бигэрмижэд хааны монгол намтар” мэт ийм зохиол Энэтхэг оронд байсан байж болох бөгөөд түүнээс уламжлан монголд нэвтэрсэн байж болох юм. Гэвч Энэтхэг оронд монгол “Бигэрмижэд хааны намтар”-ын адил ийм зохиол олддоггүй гэнэ. Энэтхэгийн аман үлгэр домог Монголд нэвтэрээд түүнийг Монгол оронд бичиж зохиол болгосон ч байж болох юм. Монгол “Бигэрмижэд хааны намтар” нь үнэхээр Энэтхэг гаралтай байлаа ч гэсэн өдий төдий сунжирч Монголын ахуй байдалд зохицож өөрчлөгдсөн байна. Ийм учраас эхийг Монголын уран зохиолын түүхэнд багтаах нь зүйтэй юм” [Дамдинсүрэн, Чанту 1983: 589] гэж үзсэн нь бидний таамаглалын нэгэн баримт болж байх нь тодорхой юм. Аль ч үндэстний аман зохиолын уламжлалд иймэрхүү үзэгдэл түгээмэл оршиж байдагийг эрдэмтэн та бүхэн яахан андах ажээ. Энэтхэгийн Бигэрмижэд хааны үйл явдал буюу нэртэй холбоотой энэхүү гурван цуврал олон үлгэр үүдээс Монгол оронд бичгээр буюу амаар хамагаас өргөн дэлгэр уламжласан нь “Арж Борж хааны намтар” нь болох юм. Иймээс энэхүү үлгэрийн тухай гадаадын эрдэмтэд нилээд эртнээс анхааралдаа авч, түүнийг хэвлэж судласан байдаг. Монгол “Арж Борж хааны тууж”-ийг хамгийн түрүүнд Буриадын эрдэмтэн Гомбын Галсан орос хэлэнд орчуулжээ, 1858 онд “Арж Борж, Монгол тууж” хэмээх нэрээр Петербурgt хэвлэжээ. Үүний дараагаар Германы эрдэмтэн Б. Юлг монгол ба Герман хэлээр орчуулж 1867 онд хэвлэсэн бөгөөд 1868 онд мөн Юлг бас “Арж Борж хааны тууж”-ийн үлгэрийг “Шидэт хүүрийн үлгэр”-ийн хамт дан Герман хэлээр хэвлэжээ. 1923 онд Оросын эрдэмтэн Жамсраны Цэвээнээс «Арж Борж хааны тууж»-ийн нэр үл мэдэгдэх хүний Орос орчуулгыг “Монгол үлгэрүүд” гэх нэрээр хэвлэсэн бөгөөд 1928 онд “Бигэрмижэд хааны намтарыг Арж Борж хаанд модон хүний өгүүлсэн үлгэрүүд оршибой” гэдэг

нэрээр Улаанбаатарт тус тус хэвлэж гаргасан байна. 1960 онд Английн монголч эрдэмтэн Ч. Бауденаас Арж Борж хааны арван дөрвөн бүлэг үлгэрийг Улаанбаатарын 1928 оны хуулж матан галиг үсгээр бичээд Англи орчуулгаа тайлбарын хамт Энэтхэгийн шинэ Дели хотноо хэвлүүлжээ. 1937 онд монголч эрдэмтэн А. Мостертоос “Ордосын аман зохиол” гэдэг том номдоо “Арж Борж хааны намтар”-ын есөн үлгэр оршил үлгэртэйгээ арван үлгэр-ийг тухайн үлгэрчийн амнаас бичиж аваад латин галиг үсгээр хэвлэжээ. 1961 онд Энэтхэгийн эрдэмтэн Рагху Вирагаас монгол “Арж Борж хааны намтар”-ын 14 бүлэгийг 1928 оны хэвлэлээс хуулж уйгаржин монгол үсгээр хэвлэсэн байна. Ингээд Хятад хэлний шинэ орчуулгаа монгол хэлнээс төвд хэлэнд орчуулсан Монгол Улсын номын санд байгаа эх орчуулгыг хавсарган хэвлэжээ. Үүнээс гадна “Арж Борж хааны намтар”-ын гар бичмэлийн хэд хэдэн хувилбарууд монгол улсын номын санд хадгалагдаж байгаа ажээ. 1958 онд Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос “Тучин хоёр модон хүний үлгэр” гэх нэрээр “Арж Борж хааны намтар”-ын үргэлжлэл болох — “Гэсна хааны намтар” хэвлэгджээ. Энэхүү намтарын эцэст “...Бандида Ачира Энэтхэгийн хэлнээс Монгол хэлэнд орчуулав” [Дамдинсүрэн, Чанту 1983: 1910] гэх орчуулгын тухай тэмдэглэл байдаг боловч Энэтхэг хэл дээрх уул номын тухай мэдээ жишээ одоо болтол тодорхойгүй байдаг.

Монгол “Арж Борж хааны намтар”-ын судалгааны талаар гадаадын эрдэмтэдээс ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Үүнд Оросын эрдэмтэн А. Н. Веселовский Славын домог яриаг судлахдаа Гомбын Галсан, Б. Юлэг нарын орчуулгыг Энэтхэгийн санскрит хэлний “Тучин хоёр модон хүний үлгэр”-гэй харьцуулан судласан байна. А. Н. Веселовский монгол “Арж Борж хааны намтар”-ын уг сурвалж болох Энэтхэгийн нэгэн тиймэрхүү үлгэрийн цоморлиг эрт цагт байсан бололтой гээд тэр сурвалж цоморлиг өдий олдохгүй болсон тухай онцлон тэмдэглэхийн зэрэгцээ тэрээр бас “бидний мэдэж байгаа санскрит хинди хэлний хувилбар нь монгол Арж Боржийн шууд үүсэл байж чадахгүй” [Веселовский 1930: 63] гэх үзэлтийг дурьдсан байдаг. Мөн энэ тухай дорно дахиныг судлагч Б. Лауферээс “Монгол утга зохиолын найруулал” гэх

номдоо “Гучин хоёр модон хүний үлгэр”-ийн тухай өгүүлэхдээ “Жинхэнэ нь монголын боловсруулсан зүйл” [Лауфер 1927: 63] гэж үзсэн байна. Английн монголч эрдэмтэн Ч. Бауденаас монгол “Арж Борж хааны тууж”-ийн 14 бүлэг үлгэрийг англи орчуулгаа тайлбарын хамт Энэтхэгт хэвлүүлэхдээ монгол “Арж Борж”-ийн зарим бүлгүүдийг бусад зохиолтой харьцуулан жишсэн ба уг зохиолыг монгол шинжтэй болгосон тухай сонирхолтой оршилыг бичсэн байна. Энэтхэгийн эрдэмтэн Рагху Вира монгол “Арж Борж хаан”-ы 14 үлгэрийг 1961 онд хэвлэсэн номын оршилдоо уг үлгэрийг Энэтхэг гаралтай гэж таамаглан бичсэн боловч монгол үлгэр гэдгийг үгүйсгэсэнгүй. Харин батлаж мөн номын эхний хуудсанд “Агуу монголын эрхэм түүхүүд” гэж нэрлэсэн байна [Дамдинсүрэн, Чанту 1983: 677].

“Монгол Арж борж хааны намтар”-ын талаар маш нарийлаг мөртөө сонирхолтой шинжилгээ хийсэн эрдэмтэн бол Монгол Улсын академич Ц. Дамдинсүрэн болох юм. Тэрээр 1977 онд Улаанбаатар хотноо хэвлэсэн “Монголын уран зохиолын тойм” гэх томоохон бүтээлдээ “Бигармижид хааны тухай гурван ном” гэх тусгай сэдвээр “Монголын Бигармижид хааны намтар”, “Арж борж хааны намтар”, “Тэсэнэ хааны намтар” гэдэг гурван номын тухай нарийн шинжилгээ хийсэн байдаг. Энэхүү өгүүлэлд дээр дурдсан гурван номын тухай нарийлан танилцуулахын зэрэгцээ уг номын үүсэл гарлыг ч нарийвчлан судалж цаашид уг номын тодорхой зарим нэгэн үлгэрийг бусад бичмэл үлгэртэй харьцуулж, энэтхэг гаралтай үлгэр нь хэрхэн монгол үлгэр болон улиран хувиссан жам хуулийг тодорхойлохоор үндсэн зорилтоо болгосон байна.

Академич Ц. Дамдинсүрэнгийн энэхүү судалгаа нь анх удаа “Бигармижид хааны тухай гурван ном”-ыг дэлхийн монголч эрдэмтдийн сонирхолд хүргэж, энэ тухай судалгааг олон улсын түвшинд хүргэсэн төлөөлөгч бүтээл болох юм. Академич Ц. Дамдинсүрэн “Бигармижид хааны тухай гурван ном” гэдэг бүтээлээ гурван хэсэгт хувааж бичжээ. Энэ нь даруй Монгол хэл дээрх “Бигармижид хааны намтар”, “Арж борж хааны намтар”, “Тэсэнэ хааны намтар” гэх гурван номыг тус бүрд нь танилцуулан

судалсан байна. Өгүүллийн эхэн хэсэгт монгол хэл дээрх “Бигармижид хааны намтар”-ын товч агуулгаас түүний судлалын тухай товч танилцуулахын зэрэгцээ тэрээр хэлэхдээ «Бигармижид хааны намтарт» «Бигармижид хаан Цэцэн хатнаа авсан түүх, түүнээс салж зовсон явдал гарна. Энэ намтар бол бурханы шашны тоос халдсан янаг амрагийн зохиол болох юм» [Дамдинсүрэн, Чанту 1983: 633] гэжээ. Эрдэмтэн Ц. Дамдинсүрэнгийн судалгаанаас ойлгоход Викрамадити гэдэг нэгэн шударга сайн хаан одоогоос хоёр мянган жилийн өмнө энэтхэг оронд байсан гэдэг боловч түүний намтар түүх тодорхойгүй мөртөө Энэтхэг оронд ч монголын Бигармижид хааны намтартай адил зохиол байдаггүй юмсанжээ. “Бигармижид хааны намтар” нь Монгол оронд бичмэлээр тархасан бөгөөд 1923 онд Улаанбаатарт “Энэтхэгийн газрын Бигармижид хааны тууж оршвой” гэдэг нэрээр хэвлэсэн байна. Монгол хэлнээс орос ба европын ямар ч хэлэнд орчуулагдсангүй мөртөө ерөөс судлагдсангүй ажээ.

Өгүүллийн хоёрдугаар хэсэгт “Арж борж хааны намтар” энэтхэгээрээ “Ража Боожа хааны намтар буюу” “32 модон хүний үлгэр”-ийн санскрит хэлт агуулгын товч, Монгол “Арж Борж хааны намтар”-ыг хэвлэж судалсан байдлаас түүний агуулга, үзэл санаа, өвөрмөц онцлог шинж гээд монгол энэтхэгийн Арж борж хааны намтрын харьцуулал гэх зэрэг хэдэн талаас монгол энэтхэгийн Арж Борж хааны намтрын нийтлэг болон өвөрмөц онцлог шинжийн тухай нарийвчлан судалгааг хийсэн байна. Эрдэмтэн Ц. Дамдинсүрэнгийн судалснаар “Бигармижид хааны тухай гурван ном” монгол хэлээр байдгаас ганц “Арж борж хааны намтар”-тай төсөөтэй ном санскрит хэлээр байдаг [Дамдинсүрэн, Чанту 1983: 591].

Энэтхэгийн “Раажа Боожа хааны намтар” буюу 32 модон хүний үлгэрийг санскрит хэлнээс орос хэлэнд оросын эрдэмтэн П. А. Гринцер орчуулж, 1960 онд хэвлэсэн байна. Эрдэмтэн П. А. Гринцер уул номын оршилд “Викрамын намтар” буюу “32 модон хүний үлгэр” бол Викрамадити хааны гавьяа зүтгэл, баатар зоригт зориулсан олон зохиолын дотроос онцгой чухал нь юм. Тэр хааны өгөөмөр өршөөл, баатарлагийн тухай домог уламжлал их

байдаг. Эдгээр зохиолд Викрамадити хааныг хүчтэй, шударга эзэн ялагдашгүй баатар ядуу доордсыг өмгөөлөгч хүн бүхнийг өршөөн хайрлагч гэж дүрсэлсэн байна гэж бичжээ [Дамдинсүрэн, Чанту 1983: 601].

Эрдэмтэн Ц. Дамдинсүрэн энэтхэгийн “32 модон хүний үлгэр” буюу “Раажа Боожа хааны намтар”-ыг монголын “Арж борж хааны намтар”-тай харьцуулж үзээд: «Энэтхэгийн 32 модон хүний үлгэрийн хэлсэн арга буюу хажилга нь монгол „Арж борж хааны намтар“-ын хажлагатай адил бөгөөд мөн 32 үлгэрээс нэг үлгэр монгол олон гар бичмэлийн нэгэнд буй ба энэтхэгийн аль нэгэн үлгэр түүхийн дотор монгол «Аарж борж хааны намтар»-тай адил төстэй зүйл ганц хоёр байгаа баримт бол монгол цоморлиг нь энэтхэг үлгэртэй ямар нэгэн холын төрө садан холбоотойн баримт болж чадах боловч, монгол “Арж борж хааны үлгэр”-ийг монгол үлгэр биш болгох баримт болж үл чадна гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг [Дамдинсүрэн, Чанту 1983: 602]. Тэрээр мөн цаашид “Монгол Арж борж хааны намтар” энэтхэг гаралтай байлаа ч гэсэн монголд нэвтрэх замдаа ба нэвтэрч ирсэн хойноо өдий төдий өөрчлөгдсөөр танихын аргагүй хувирсанаар үл барам монгол ахуй байдлыг тусгасан өөр үлгэриг нэмж оруулсан бололтой байна гэж үзсэн байна [Дамдинсүрэн, Чанту 1983: 635].

Өгүүллийн гуравдугаар хэсэгт “Гэсэнэ хааны намтар”-ын товч агуулгыг танилцуулахын зэрэгцээ түүнийг энэтхэг хэлнээс монгол хэлэнд орчуулсан тухай асуудлыг тодорхойлохоор үндсэн зорилтоо болгосон байна. Эрдэмэн Ц. Дамдинсүрэнгийн судалснаар “Гэсэнэ хааны намтар” бол “Бигармижид хааны тухай гурван ном”-ын сүүлийнх нь болно. Энэ зохиолыг энэтхэгийн санскрит буюу ямар нэгэн хэлнээс монгол хэлэнд хоёр удаа орчуулсан байна. Үүний нэг орчуулгыг “32 модон хүний үлгэр” нэртэйгээр Чуулалт хаалган хотод 1958 онд хэвлэж гаргасан байна. Үүнд ижил нэг гар бичмэл Монгол Улсын номын санд бий [Дамдинсүрэн, Чанту 1983: 628].

Энэ хоёр орчуулгын нэгийг Багахан бандид гэдэг хүн орчуулсан бөгөөд нөгөөхийг нь Бага бандида гэдэг хүн орчуулсан ажээ. Энэ тухай тэрээр «миний санаанд „Гэсэнэ хааны намтар“ гэж хэрвээ тийм бичмэл зохиол Бага бандида нарын гарт байсан бол тэр нь жинхэнэ (цэвэр) энэтхэг байгаагүй. Харин Балба, Төвд оронд их

улирч хувирч өөрчлөгдсөн зохиол байсан бололтой» гэж үзсэн байна [Дамдинсүрэн, Чанту 1983: 629].

Академич Ц. Дамдинсүрэн энэхүү судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг хийсэн байдаг: “Бигармижид хааны намтар”, “Арж борж хааны намтар”, “Гэсэнэ хааны намтар” гэх гурван ном хэлбэрийн талаар энэтхэгийн 32 модон хүний үлгэртэй төстэй. Зохиолын баатрын нэлээд нь энэтхэг нэртэй. Үлгэрийн зарим нь энэтхэг үлгэрээс гаралтай байна. Гэвч энэтхэг хэлнээс орчуулсан энэтхэг зохиол гэж үзэж болохгүй. Харин монгол ардын түмний уран бүтээл гэж үзэх хэрэгтэй болно. Зарим энэтхэг гаралтай үлгэр байвч тэр нь монголын ард түмний дунд олон зуун жилээр оршиж, монгол ахуй байдалд нийцэж жигд хувирсан байна. Эдгээр гурван ном бол монгол-энэтхэгийн ард түмний эртний уламжлалт соёлын холбооны гэрч болсон монгол үлгэрийн цоморлигууд болно гэжээ [Дамдинсүрэн, Чанту 1983: 673].

Манай улсад “Арж борж хааны намтар”-ыг тусгай сэдвээр судалсан бүтээл хараахан үгүй гэж хэлж болно. Үүнд нэгэн зүйлийг дурдахад Шинжааны их сургуулийн Ч. Бат профессор «„Нарандалай хаан ба түүний хоёр хөвүүн“-ээс сэдэвлэн өгүүлэх нь» гэдэг өгүүлэл нийтэлжээ [Мөнх, Бат 1998: 122]. Ойрадын “Нарандалай хаан” гэх туулийг монгол “Арж борж хааны намтар”-ын зарим нэгэн бүлгийн үйл явдалтай харьцуулж, тус тууль нь энэтхэгийн “Арж борж хааны намтар”-аас үүсэлтэй гэх үзэлтийг дурьдсан байна.

Бидний үзэхээр энэхүү өгүүлэлд дараах хэдэн талын сэжиглэлтэй асуудал оршиж байх шиг санагдана. Үүнд:

1. Энэтхэгийн “Раажа Боожа хааны намтар” буюу “32 модон хүний үлгэр” нь монгол “Арж борж хааны намтар”-тайгаа өсөд өөр, үйл явдалтай байгааг сайтар судалж үзсэнгүй бололтой. Монгол “Арж борж хааны намтар” нь хэдийгээр энэтхэгийн “Раажа Боожа хааны намтар”-аас эх гаралтай гэдэг боловч үлгэрийн доторх үйл явдал нь эрс өөр байдаг ажээ.

2. Монгол “Арж борж хааны намтар” нь энэтхэг намтартайгаа нэрийдэл, зохиолчийн талаараа адил байдаг боловч, зохиолын үйл явдал нь монгол амьдралаар баялагжсан монгол зохиол болох юм.

Монгол үлгэрээр зохиогдсон монгол уран бүтээл нь хоорондоо үлгэрийн гэх шинж болон мотивын талаараа адилавтар зүйл олон байх нь аяндааны хэрэг. Тэр ч байтугай хоорондоо ямар ч харилцаа холбоогүй улс үндэстний аман зохиол ч хоорондоо адилавтар зүйл олон тохиолддогийг хэн бүхэнд мэдээж юм.

3. Адилавтар зүйл бүхнийг заавал нэг нь нөгөөгөөсөө зээллээ гэдэг нь учир дутагдалтай болдог тухай академич Ц. Дамдинсүрэн багш маш шинжлэх ухаанч өөрөөр заан гаргасан байдаг.

Бидний ойлгосноор зарим нэг эрдэмтдээс явган болон тууль хоорондоо ямар нэг хэрмээр зааглагдсан юм шиг хэн нь хэнээсээ ямар нэгэн мотивыг зээлж авдаг гэж үздэг нь учир утагдалтай болсон шиг санагдана. Учир юу гэвэл аливаа үлгэр үйл явдалтай аман бүтээлүүд нь хамтдаа тогтсон нэг хэв загварт яригддаг. Өөрөөр хэлбэл тэдгээрийн үйл явдлууд нэг ерөнхийдөө тогтонгуй байдаг мөртөө тодорхой хэмжээний хэв шинж мотивуудаас бүтдэг. Тэдгээр үйл явдлууд нь хэрхэн хоорондоо нийлэлдэн бүтэж ямар нэгэн стилийн зохиолыг бүтээнэ гэдэг нь үлгэрч болон туульчийн ур мэргэжилтэй холбогддог. Үүнд үлгэрийн ямар нэгэн үйл явдлын хэв гэх шинж болон мотивууд нь аль нь алиных нь гэсэн тодорхой ялгаа байдаггүй. Нэн тодорхойлж хэлэхэд туулийн мотив явган үлгэрийн мотив гэж хэн нь хэнээсээ зээллээ гэдэгтодорхой тогтсон зааг байдаггүй. Тэгэх мөртөө эдгээр үлгэрийн үйл явдлын гэх шинж болон мотивууд нь улс үндэстэн алслан хоорондоо адил зүйл арвин байдгийг АТ-ны ангилал бидэнд тодорхой зааж харуулсан байдаг. Сүүлийн үед Оросын Буриад, Халимаг, Монгол улсаас манай улсын Өвөр монгол, Шинжаан, Хөх нуур зэрэг монголчуудын төвлөрөн суурьшиж байгаа орноос “Арж Борж хааны намтар”-ын зарим нэг хэсэг үлгэрийн аман хувилбаруудыг эмхтгэн цуглуулж, тухайн нутаг орны аман зохиолын түүвэрт оруулан хэвлэсэн нь бидний судалгаанд туйлын ховор нандин эх хэрэглэгдэхүүнийг хангасан гэдгийг энд тэмдэглэхэд таатай байна. Жишээлбэл: Оросын Буриадаас хоёр хувилбар олдож буй. 1-р хувилбар нь 1973 онд Улаан-Үдэд хэвлэсэн “Буриад ардын үлгэрүүд” гэх номонд орж хэвлэгджээ. Тус хувилбарыг 1945 онд

Буриад улсын Түнхэн аймгийн Замчок тосгоны М. А. Алексееваас тэмдэглэж авсан байна (Үүнийг бид хувилбар гэж нэрлэнэ.)

Хоёрдугаар хувилбарыг “Буриад ардын аман зохиолын түүвэр” гэх номонд орж Улаан-Үдэд хэвлэгджээ. Энэхүү хувилбар нь 1945 онд Буриад улсын Аг мужийн Ботала тосгоны Т. Чимитовагаас тэмдэглэн авч (эхийг нь бид Б хувилбар гэж нэрлэнэ). Халимагаас гурван хувилбар олдож буй. Энэхүү гурван хувилбараас нэг хувилбар нь бидний судлах гэж байгаа монгол “Арж борж хааны намтар”-ын нэгэн хэсгийн хувилбар биш тул энд танилцуулахгүй. Нөгөө хоёр хувилбарын нэг нь “Арж борж хаан” гэсэн нэртэйгээр “Халимаг туульс” гэх номонд хоёрдугаар ботид оржээ. 1968 онд Элстэй хотноо “Халимаг хэвлэлийн хороо” хэвлэжээ. Тус хувилбарыг Манжийн Санжаас тэмдэглэн авч, гэхдээ хэзээ тэмдэглэж авсан нь тодорхойгүй (эхийг бид А хувилбар гэж нэрлэнэ). Нөгөөх нэг хувилбар нь “Долоон настай заргач” гэдэг нэрээр «Халимаг туульс» гэх номын I-р ботид сонгогдон орж, 1961 онд Элстэй хотноо Халимаг хэвлэлийн хороонд хэвлэжээ. Энэ хувилбарыг хэзээ хэнээс тэмдэглэн авсан нь тодорхойгүй. (үүнийг Б хувилбар гэж нэрлэнэ).

Монгол Улсаас одоо болтол сүүлийн үеийн аман хувилбарууд олдоогүй боловч 1928 онд Улаанбаатар хотноо хэвлэгдсэн монгол “Арж борж хааны намтар”-ын бичмэл эх олдож буй. Хэзээ тэмдэглэгдсэн нь тодорхойгүй.

Үүнээс гадна манай улсын Ордос, Өвөр Монголын, Шинжаан, Хөх нуур зэрэг газраас “Арж борж хааны намтар”-ын зарим нэг хувилбарууд олдож буй. Тухайлбал: Шинжааны Ховог сайраас “Арж борж хан” гэдэг нэртэй Арж борж хааны оршил бүлгийн хувилбар олдож буй. Энэхүү хувилбарыг манай улсын НШУА-ийн судлаач Б. Дамиранжав 1980-аад онд Ховогсайр сианы III малын талбайн малчин Б. Тогтохоос тэмдэглэн авч, “Зургаадай мэргэн” гэх номдоо сонгон оруулж, 1988 онд ӨМСХХ-оос хэвлүүлсэн байна. Хөх нуурын хувилбар нь “Зандан ширээ” гэдэг нэртэйгээр “Хаашийн явган үлгэр” “Хятад дотоод хэвлэл” гэх номонд сонгогдон орж, 1990 онд хэвлэгджээ. 1988 онд Оюунбилэг Хөх нуурын Голмуд хотын Урт мөрөн сианы Хашаат тосгоны малчин

67 настай Жамсрангаас тэмдэглэн авч, энэ нь мөн монгол “Арж борж хааны намтар”-ын оршил үлгэрийн хувилбар болох юм.

Өвөр Монголын Ордосоос хоёр хувилбар олджээ. I хувилбар нь 2009 онд ҮХХ-ноос хэвлэгдсэн “Морин цагаан сувд” гэх ордос ардын явган үлгэрийн цуглуулгад орсон “Товцогийн долоон хүү” (үүнийг бид А хувилбар гэж нэрлэнэ) гэх хувилбар болно. Энэ хувилбарыг 1980-аад онд Ордосын ахмад үлгэрч Цограваас тэмдэглэж авсан байна. Тэмдэглэсэн хүн нь тодорхойгүй.

II хувилбар нь 1937 онд Белгийн монголч эрдэмтэн А. Мостэроос “Ордосын аман зохиол” гэдэг том номдоо “Арж борж хааны намтар”-ын 9 үлгэр (оршил үлгэртэйгээ 10 үлгэр)-ийг тухайн үлгэрчийн нарын амнаас бичиж аваад, латин галиг үсгээр хэвлэжээ. Бидний энд шинжлэх гэж байгаа хувилбар (үүнийг Б хувилбар гэж нэрлэнэ) бол 1982 онд ҮХХ-оос хэвлэсэн А. Мостэрын “Арж борж хаан” гэх номонд доторх “Арж борж хааны оршил үлгэр” нь болох юм. Дээр дурьдагдсан хувилбаруудаас үзэхэд монгол улс болон Ордосын хувилбарыг гаргавал бусад хувилбарууд нь олонхидоо сүүлийн үед цуглуулагдсан монгол “Арж борж хааны үлгэр”-ийн эхний хэсгийн аман хувилбарууд болох нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл 32 модон хүнээс Арж борж хаанд өгүүлсэн үлгэрүүдийн эхлэлтийн хэсэг нь болох юм. (Бид доройш “Арж борж хааны намтар”-ын оршил үлгэр гэж товчилно.) Иймээс бид энэхүү өгүүлэлдээ голдуу монгол Арж борж хааны намтарын оршил үлгэрийн аман буюу бичмэл хувилбаруудыг хооронд нь харьцуулахаар дамжин доторх нэг үлгэр нь уламжлалын явцдаа хэрхэн улиран хувьсдаг жам хуулийг эрэлхийлэхээр үндсэн зорилгоо болгосон болно.

II. Монгол оронд уламжилсан Арж борж хааны үлгэрийн аман буюу бичгийн хувилбаруудыг харьцуулах нь

Бидний ойлгосноор монгол “Арж борж хааны намтар” нь ХХ зууны эхний үед Монгол газраар машинд дэлгэрч байсан нь тодорхой мэдэгдэж буй. Нэн ялангуяа Монгол улс, Оросын Буриад, Халимаг цаашлаад манай улсын Ордос, Шинжаан зэрэг

газар орноор аман буюу бичгээр жигд уламжилж байсан бололтой. Сүүлийн үе болж ирээд энэхүү уламжлал нь бараг тасрах зүгтээ хандаж, энэхүү үлгэрийг мэдэх үлгэрч цөөрөхийг дагалдан үлгэрийн үйл явдлын зохиомжинд ихээхэн хувиралт гарч, уулын цуврал олон хэлхээ үлгэрүүд нь нийлэх буюу өөр шинэ нэгэн үлгэрийн хэв шинжээр баялагжиж, Монгол маягийн эхийг нэгэн явган үлгэрийн шинжтэй болсон байдалтай. Үүний нэг тодорхой жишээ гэвэл сүүлийн үед Монгол орноос тэмдэглэж авсан хувилбаруудаас үзэхэд олонхдоо монгол “Арж борж хааны намтар”-ын оршил үлгэрийн хувилбар буюу “намтар”-ын доторх зарим нэгэн үлгэрийг оршил үлгэртэй нь нийлүүлэн, эхний нэгэн биеэ даасан үлгэрээр ярих болсон нь тодорхой мэдэгдэж буй. Бүүр сүүлдэж ирэхэд “Арж борж” гэдэг энэтхэг нэр нь хэлэхгүйгээр ярих болсон байх жишээтэй. Дахин жишээлэхэд бидний мэдээчээр энэтхэгийн Раажа боожа хааны намтар буюу “32 модон хүний үлгэр” нь 32 үлгэрээс бүтсэн байдаг бол харин монгол “Арж борж хааны үлгэр”-ийн эл хувилбарууд нь хамаг олондоо зөвхөн 14 үлгэрээс бүтсэн байдаг ажээ. Энэ нь энэ хоёр үндэстний дунд адил нэртэй адил зохиомжтой, үйл явдал нь өсөд өөр үлгэрүүд зохиогдсон гэдгийг тодорхой харагдаж байна. Энэ нь анх эхэндээ энэтхэгийн Раажа Боожа хааны намтар буюу “32 модон хүний үлгэр” нь аман уламжлалын хэлбэртэй, монголчуудын дунд уламжилж урт удаан оны аман уламжлалын явц дунд монголчууд өөрийн ахуй амьдралдаа зохицуулан энэтхэг үлгэрийн хэв загварыг ашиглан шинээр дахин зохиосон монгол үлгэр болохыг гэрчилж буй. Энд бид зөвхөн “Арж борж хааны намтар”-ын эхний хэсгийн оршил үлгэрийн хувилбаруудыг харьцуулахаар дамжуулан, энэтхэгийн тухайн үлгэр нь хэрхэн монгол үлгэр болоод хувиссан тухай асуудлыг авч хэлэлцэх болно. Академич Ц. Дамдинсүрэн энэ үлгэрийн тухай судлахдаа голдуу нэлээд дээр үед тэмдэглэгдсэн бичгийн хувилбарууд дээр суурилж судалсан бол бид энд голдуу сүүлийн үе болтол монгол газар орноор уламжлан яригдаж байсан аман хувилбар дээр тулгуурлан бичгийн хувилбартай нь харьцуулан судалж, тухайн үлгэр нь уламжлалын явцдаа хэрхэн улиран хувиссан жам хуулийг нь эрэлхийлэх болно.

Сүүлийн үеийн аман хувилбаруудаас үзэхэд монгол “Арж борж хааны үлгэр”-ийн эхэн хэсгийн оршил үлгэр нь дангаараа биеэ даасан үлгэр болон яригддаг юм байна. Өөрөөр хэлбэл уулын бичигт тэмдэглэгдсэн хувилбаруудтай адил 32 модон хүний өгүүлсэн үлгэрийн оршил үлгэрээр яригддаггүй, харин биеэ даасан үлгэрийн хэлбэрээр яригддаг. Энэ нь ямар нэгэн үлгэрийн уламжлалын түүх нь урт болох тусмаа тухайн үлгэрийн үйл явдал нь тасралтгүй өөрчлөгдөж, өөрийн үндэстний эх хэл соёл түүх зан заншилдаа зохицон уламжлагддаг гэсэн жам ёсыг харуулж буй. Дараа нь бид бичгийн болон аман хувилбаруудын үйл явдалд тус бүрд нь дөхөм тоочилт хийж, хооронд нь харьцуулж үзье.

Халимагийн аман хувилбар: (А хувилбар)

1. Хэзээний бас нэгэн Уу цагт таван хошуу малтай Арж борж хаан гэдэг нэг хаан байжээ. Тэр хаан буруу гаргасан хүний заргыг шүүдэг хаан байжээ гэнэ.

2. Нэгэн залуу гадаад далайгаас морин толгойтой эрдэнэ олж нөгөөх нэг нөхдүүддээ өгч, манай эхнэрт өгчих гээд явуулахад нөгөө хүүд нь өгсөнгүй дундаас нь авсан байжээ. Ингээд Арж борж хаанд зарга мэдүүлэхэд, Арж борж хаан буруугаар шүүсэнд уул толгойд (нуугдаж байсан) тугал, хонь, ямаа хариулж байсан хөвгүүдээс морин толгойтой эрдэнэ нь хэний болохыг зөвөөр шүүж, чадсан гэнэ.

3. Нэгэн үхэрчин айлын цэрэгт явсан хөвгүүн нь хоёр ав адилхан төрсөн хөвгүүн болоод гэртээ харьж иржээ. Хөвгүүдийн ааваас нь хүүгээ таньж чадах үгүй, Арж борж хаанаар шүүлгэхэд хаан буруу шүүж, ингээд уулын толгойд тугал, хонь, ямаа хариулж наадаж байсан хөвгүүдээс аль жинхэнэ хөвгүүн болохыг зөвөөр шүүж хөвгүүнд хувилсан шулмыг лонхонд оруулан дарсан гэнэ.

4. Арж борж хаан гайхаш алдаж, тэр хөвгүүдийг өдөр болгон нуугдаж байдаг уулын толгойг малтуулсанд найман хөлтэй цагаан өнгөтэй ширээ гарч ирж гэнэ. Арж борж хаан тэр ширээн дээр сууснаас их ой ухаантай сайн заргач хаан болж гэнэ.

Бидний ойлгосноор “Арж борж хааны намтар” нь халимаг монголоос гадна, оросын буриад, монгол улс нэн цаашдын Өвөр Монгол, Шинжаан, Хөх нуур зэрэг газар орны монголчуудын

дунд ч өргөнөөр тархсан байх жишээтэй. Тэгэх мөртөө “Арж борж хааны үлгэр”-ийн оршил үлгэр нь янз бүрийн хувилбартайгаар монгол оронд ихээхэн тархсан нь бидний анхаарлыг ихээхэн татаж байна. Бид эдгээр газар орны “Арж борж хааны үлгэр”-ийн оршил үлгэрээс хамгийн онцлогтой гэсэн хэдэн хувилбарыг авч үзье.

Оросын буриадын аман хувилбар

А хувилбар

1. Сүн далай нуур байхад Сүмбэр уул нь болдог (уул довцог) байхад Арж борж хаан суу гэнэ. Хэргийг нь хөтлөх хоёр түшмэлтэй гэнэ. Баруун хойноо нүцгэн болдогтой юм гэнэ. Болдог дээр нь айлын хүүхдүүд уралдаж нааддаг гэнэ. Нэг нь уралдсан нь ардын ноён болж нааддаг гэнэ.

2. Арж борж хааны нэг албатын Зүг гэдэг нэртэй хөвгүүн алсад явж, шижир алтан улаан өөрийн айлын Аврам гэдэг нэртэй хөвгүүнд өгч гэртээ өгчих гээд явуулахад тэр хөвгүүн нь алтыг нь өгөлгүйгээр өөрөө худалдаж идсэн гэнэ. Ингээд Зүг хөвгүүн Арж борж хаанд Аврам хөвгүүнийг заалджээ. Хаан заргыг буруугаар шийдсэнд болдог дээр нуугдсан хөвгүүнээс заргыг зөвөөр шүүлгэж чадсан гэнэ.

3. Арж борж хааны нэг түшмэлийн хөвгүүн нь цэргийн албанд 3 жил яваад гэртээ хүрч ирэхэд бас нэг ав адилхан төрсөн хөвгүүн ирэхэд ааваас нь хоёр хөвгүүнийг ялган таньж чадсангүй, хаанаар зарга шүүлгэхэд хаан шулам хөвгүүнийг нь жинхэнэ хөвгүүн болгож буруугаар шүүхэд болдог дээр нуугдсан хүү заргыг дахин шүүж, шулам хөвгүүнийг лонхонд оруулж галдаж алсан гэнэ.

4. Арж борж хаан өдөр туршид мах иддэг зуршилтай юмсанжээ. Нэг удаа хааны иддэг мах нь барагдсанд тогооч нь мах бэдэрч (хайж) үхсэн хүүхдийн махыг авчирч чанаж өгчээ. Хаан үхсэн хүүхдийн мах идээд: “амттай сайхан мах байна” гээд түүнээс хойш айлын хүүхдийн махаар хооллох болсон гэнэ.

5. Айлын хөвгүүд баригдаж ховор болоход болдог дээр нуугдсан хөвгүүн гайхалдаж, айл болгоны гадаа сахиул тавьсанд хааны тогооч айлын хүүхдүүдийг алаад явж байхыг барьж аваад махчин хаанаа алж болдог дээр нуугдсан хөвгүүдээс хоёр нь ноён болж, ард зоноороо амар сайхан жаргаж гэнэ.

Шинжааны аман хувилбар

1. Эрт урьд цагт Арж борж гэдэг нэгэн хаан байсан гэнэ. Тэр хааны гэрийн өмнө биед нэг бага уул байх бөгөөд тэр уулан дээр өдөр бүр зарцынх нь 7 хөвгүүд салж (ээлжилж) хан сууж нааддаг гэнэ.

2. Нэг өдөр 7 хөвгүүн наадаж байтал нь тором хөтөлсөн хүн нь дуулж, нөгөө хүн нь уйлж явахыг хан сууж нуугдаж байсан хөвгүүн үзээд тэднийг дуудаж, та хоёрын нэг нь яагаад дуулж, нөгөө нь яагаад уйлж байна вэ? гэж асуусанд уйлж явсан нь энэ хүн миний торомыг аваад өөрийн тором гэв. Тэгээд арж борж хаанд хүргэсэнд хаан буруугаар шүүж, түүнд өгөв. Хан суугч наадаж байсан хүн үүнийг сонсоод тэгвэл торомын эхийг нь авчир гээд явуулжээ. Тэгэхэд хөвгүүн маргааш нь торомын эхээр нь тормын жинхэнээс нь хэн болохыг нь таньж, хаанд чимээ илгээжээ. ... Учир явдлыг шүүвэл тань шиг сүйтгэл болохгүй гэж донгодсон гэнэ.

3. Маргааш нь хөвгүүн тугалаа тууж, уулын өвөрт хан түшмэд болоод наадаж байтал, хоёр хүний нэг нь уйлж, нэг нь дуулсан ирж явна гэнэ. Хаан суугч наадаж байсан хөвгүүн үзээд тэднийг дуудуулжээ... та хоёр яагаад нэг нь уйлж, нөгөө дуулж явна вэ гэхэд уйлж яваа нь би хэддэн жил цэрэгт яваад гэртээ харьж ирэхэд энэ хүн надаас түрүүлж ирээд аав ээж хоёрын минь хөвгүүн болж сууж орхижээ. Тэгээд аав ээж ч танихгүй болжээ. Тэгээд Арж борж хаанд одсонд намайг сүүлд ирсэн учраас аав ээжийн хөвгүүн биш гэж хэлэв гэжээ. Хөвгүүнүүнийг сонсоод маргааш нь тэр хоёрыг холоос уралдуулж, шулам залууг лонхонд оруулж бөхлөөд хаанд хүргэжээ. Учир явдлыг шүүвэл ингэж шийтгэдэг гэж тунхаглаж гэнэ.

4. Арж борж хаан гайхаш алдаж, хүүхдийн нааддаг уул оройг малтуулсанд дороос нь нэг 32 хөлтэй модон ширээ гарч, хаанд ... энэ ширээ бол Бигармижид хааны суух ширээ юм гээд нисэн гарахад хаан цавчихад нэг хөл нь унаж иржээ. Энэ хөлийг нь нэг баян айл аваад үүдэндээ шаантаг тавьсан гэнэ. Тэгээд энэ шаантаг нь олон бүгдэд тусалсан гэнэ.

Хөх нуурын аман хувилбар

1. Эрт урьдын цагт нэг голын тохойд хоёр айл суудаг юм байж гэнэ. Нэг айл нь эвэртэй үхэр, нөгөө айл нь мухар үхэртэй гэнэ.

2. Нэг өдөр мухар үхэртэй эзэн нь үхрээ үзэхээр очиход мухар үхэр нь нэг барсыг мөргөөд алсан байжээ. Мухар үхрийн эзэн нь баярлаад барсын арьсыг нь өвчиж аваад гэртээ харихад эвэртэй үхрийн эзэн нь сонсоод ... Эвэргүй үхэр яагаад ч барсыг мөргөж алах юм. Миний эвэртэй үхэр мөргөж алсан гээд хоёулаа зөрчил үүсгэж ханд зарга мэдүүлэхээр явжээ.

3. Хааны ордонд явах замын хажууд нэг довцог дээр 7, 8 хүүхэд өдөр болгон хан түшмэл болон нааддаг юм гэнэ.

4. Үхрийн хоёр эзэн хаанд өөрийн учир явдлаа хэлэхэд хан сонсоод ... Мухар үхэр яагаад ч барсыг мөргөж алах юм. Лав эвэртэй үхэр нь мөргөж алсан гээд барсын арьсыг нь эвэртэй үхрийн эзэнд өгчээ.

5. Үхрийн хоёр эзэн гэртээ харих замдаа довцог дээр наадаж байсан хүүхдүүдийн хажуугаар гарахдаа тэдний заргыг тэгээд шүүх болжээ. Хүүхдүүд тэр хоёрт та хоёр харьж өөр өөрийн үхрээ хөтөлж ир гээд явуулсны дараа барсын арьсанд нь өвс чихэж босгож зогсоож гэнэ. Эвэртэй үхэр нь энэхүү хуурмаг барсыг үзэнгүүтээ зугатааж эвэргүй мухар нь мөргөж унагасан тул барсын арьсыг нь мухар үхрийн эзэнд өгсөн гэнэ.

6. Тэр үест нэг газарт ядуу эмгэн өвгөн хоёр амьдардаг юм гэнэ. Эмгэн өвгөн хоёр цорын ганц хөвгүүнтэй юм гэнэ.

7. Ганц хөвгүүн нь гадагш гарч юм хайж яваад нэг морин толгойтой болор эрдэнэ олжээ. Гэртээ харих замдаа өөрт нь ав адилхан төрсөн залуутай тааралдаж, болор эрдэнээ тэр залууд өгч, манай гэрт хүргээд өгчих гээд өөрөө үргэлжлэн эрдэнэ хайхаар явж гэнэ.

8. Шулам залуу нь нөгөөх залуугийн аав ээж дээр ирж эрдэнийг нь өгөөд өөрийн хөвгүүн нь болж амьдарч гэнэ. Жинхэнэ хөвгүүн нь яваад юм олсонгүй, гэртээ харьж ирэхэд өнөөх шулам залуу нь аав ээжийнх нь хөвгүүн болсон байжээ. Аав ээж нь энэ хоёр хөвгүүнийг ялган таньж чадахгүйдээ хаандаа зарга мэдүүлэхэд хаан шулмыг жинхэнэ хөвгүүн гэж шийджээ.

9. Гэртээ буцах жилдээ довцог дээр нааддаг хүүхдүүдийн хажуугаар гарахад тэдний дуудаж, заргыг дахин шүүнэ гэжээ. Ингээд шулам залууг шивэр лонхонд оруулж амсарыг нь бөглөөд ийнхүү залуу аав ээжид нь таниулан өгсөн гэнэ.

10. Хан үүнийг сонсоод гайхаш алдаж хүүхдүүдийн нааддаг довцогийг малтсанд нэг зандан ширээ гарч гэнэ. Тэр хаан энэхүү зандан ширээн дээр сууснаас хойш элдэв хэрэг заргыг зөвөөр шүүж чадах болсон гэнэ. Уул нь тэдгээр хүүхдүүд заргыг зөвөөр шүүж чаддагийн шалтгаан нь тэрхүү зандан ширээнээс болсон гэнэ.

Өвөр монголын Ордосын аман хувилбар

А хувилбар

1. Эрт урьдын цагт нэг довцог толгойн ойр орчимд тойрон суусан олон айл байжээ. Тэр айлын олон хүүхдүүд малдаа явахдаа довцогийн өөд уралдан гарч, ноён түшмэл болж нааддаг гэнэ.

2. Нэг айлын 7 настай хүү нь алга болоод 7 жилийн дараа хүрч ирэхдээ бас нэг ав адилхан төрсөн хүү иржээ. Хоорондоо аав ээжээ булаацалдаж, аав ээж нь аргагүй заалдсанд яамны ноёноос хуурмаг хүү нь жинхэнэ хүү болгож шүүхэд довцогийн 7 хөвгүүд ноёноос заргыг дахин шүүж, чөтгөр хүү нь лонхонд орж дарагдсан гэнэ.

3. Дахиж байтал довцогийн нэг айл нь нөгөөх айлын минь молор эрдэнийг хулгайлав гэж яаманд заргалджээ. Ноёноос заргыг буруу шүүсэнд нөгөө хүүхдүүдийн ноён дахин шүүж, молор эрдэнийн эзэн нь хэн болохыг зөв шүүж чадав гэнэ.

4. Дахиж байтал мухар үхрийн эзэн болон эвэртэй үхрийн эзэн хоёр нэгэн үхүүлсэн барсын арьсыг булаацалдаж яамны ноёнд заалдсанд ноён буруу шийдэж, нөгөө 7 хөвгүүн дахин шүүж, мухар үхэр барсыг мөргсөн нь үнэн болохыг баталж, арьсыг мухар үхрийн эзэнд өгөв гэнэ.

5. Довцогийн 7 хүүхдийг яамны ноён болгосноос хойш тэр хавийн айлын ард ийм тийм хэрэг заргад учирсангүй, сайхан жаргасан гэнэ.

Өвөр монголын Ордосын аман хувилбар

Б хувилбар

1. Эрт нэгэн цагт Арж борж нэртэй нэг их хаан байж гэнэ. Тэр хааны үр 7 айлын 7 хөвгүүн нэг довцог дээр цугларч тоглоод, малаа адгуулдаг юм байна. Тэр хэдүүлээ өдөр болгон тэр довцог руу уралдаж гэнэ. Хэн нэг түрүүлсэн нь хаан болж, бусад түшмэл болж нааддаг юм гэнэ.

2. Тэр үест тэр газрын нэгнийх нь нэр нь Зууны, нэгнийг нь нэр нь Нэтгэ гэдэг хоёр хүн эрдэнэ худалдаж авахаар далайн чанадад очоод эрдэнэ худалдаж аваад, Нэтгэ нь харих болсонд Зууны нь худалдаж авсан эрдэнээ Нэтгэд өгч, миний эхнэрт өгчих гээд явуулжээ. Нэтгэ харьж ирэхдээ Зууны өнөөх эрдэнийг эхнэрт нь өгөлгүй, дундаас нь өөртөө авсан гэнэ. Хэдэн сар болоод зууны гэртээ харьу ирэхэд эхнэрээсээ эрдэнийг асууж, эрдэнэ аваагүйг мэдэн хаанд заалдтал, хаан буруу шүүв. Энэ үед довцог дээр тоглож байсан 7 хүүхэд заргыг зөв шүүж, эрдэнийг Зууныд буцааж гэнэ.

3. Ингэж байтал нэг айлын хүү цэрэгт яваад харьж ирэхэд нь бас нэг ав адилхан төрсөн хүү гэрт нь иржээ. Аав ээж нь тэр хоёр хөвгүүнийг ялган таньж чадалгүй Арж борж хаанд зарга мэдүүлтэл хаан шулам хүүг нь жинхэнэ хүү нь болгож буруугаар шүүв. Довцог дээрх нааддаг хүүхдүүдээс заргыг дахин шүүж, шулам хүүг лонхонд оруулж, Арж борж хаанд илгээхэд, хаан түүнийг түлж алж гэнэ.

4. Энэ хэрэг барсан хойно хаан гайхаш алдаш, довцогт учир буй гээд малтсанд 32 модон шүдтэй, шүд бүрт нь нэг модон хүүхэд хатгасан алтан ширээ гарчээ. Хаан тэр ширээг үзээд маш их баярлаж ширээн дээр суух гэтэл 32 модон хүүхдийн нэг нь үг хэлж, түүнийг хориглоод Бигармижид хааны үлгэрийг хаанд хэлж гэнэ.

Монгол улсын бичигт тэмдэглэгдсэн хувилбар

1. Эрт урьд Энэтхэгийн оронд Арж борж нэрт нэгэн их хаан байж гэнэ. Тэр хааны улсын хүүхдүүд тугал хариулан наадахдаа нэг довцог толгой дээр гарч бүгдээрээ уралдаж, түрүүлсэн нь хаан, бусад нь сайд түшмэл хиа болж нааддаг гэнэ.

2. Ингэж байтал тэр их хааны нэг албат далайгаас эрдэнэ олоод Зүг нэрт таних хүндээ өгч гэртээ өгчих гээд явуулахад тэр хүн эрднийг нь өгөлгүй өөрөө худалдаж идсэн гэнэ. Эрдэнээ явуулсан хүн нь гэртээ харьж бүх учрыг мэдээд, Зүгийг хаанд заалджээ. Хаан заргыг буруу шүүсэнд довцог толгой дээр нааддаг хүүхдүүд зөв шүүж чадсан гэнэ.

3. Арж борж хааны нэг түшмэлийн ганц хөвгүүн нь цэргийн албанд 2 жил яваад гэртээ харьж ирэхэд бас нэг адилхан хүү гэрт нь ирсэн байж гэнэ. Аав ээж нь танилгүй хаанд заалдтал хаан заргыг буруу шийджээ. Гэтэл довцог дээрх хүүхдүүд зөв шүүж, шулам хүүг барьж хаанд илгээхэд, хаан түймэрдэж алсан гэнэ.

4. Ингээж Арж борж хаан гайхаш алдаж тэрхүү довцог толгойд учир буй гээд малтсанд нэгэн 32 гишгүүртэй, гишгүүр бүрт 32 модон хүнийг сийлэн хатгасан алтан ширээ гарч гэнэ. Хаан үзээд баярлаж суух гэхэд 32 модон хүн үг хэлж, хаан ширээнд суулгахыг хориглож, Бигармижид хааны үлгэрийг хаанд өгүүлсэн гэнэ.

Дээрх газар орны хувилбаруудын харьцууллаас юуны өмнө бид монгол Арж борж хааны намтар монголын газар нутгаар өргөн уламжлан тархсан гэдэг байдлыг тодорхой ойлгож болох юм. Нэн түүний дотор монгол Арж борж хааны намтрын оршил үлгэр нь маш олон хувилбартайгаар уламжлагдаж ирсэн гэдгийг ч ойлгож болох байлтай. Дээрх газар орнуудын монгол Арж борж хааны намтрын оршилын үлгэрийн хувилбаруудыг харьцуулж дээрх хэдэн хэв шинжээс нийлж бүтээсэн нийлмэл үлгэр болох нь тодорхой юм. Бид эл хувилбаруудын агуулгыг нь үндэслэн дараах хэдэн хэв шинжүүдэд хувааж болох шиг санагдана.

1. “Молор эрдэнэ нь хэний болохыг шүүсэн нь” гэх хэв шинж. Иймэрхүү хэв шинжээр яригддаг хувилбарын дотор халимагийн нэг хувилбар (А), буриадын нэг хувилбар, Ордосын хоёр, Монголын нэг хувилбар буй.

2. “Шулам хөвгүүнийг лонхонд оруулж дарсан нь” гэх хэв шинж. ... Иймэрхүү хэв шинжээр яригддаг хувилбарын дотор халимагийн хоёр хувилбар, буриадын нэг хувилбар, Шинжааны 1, Ордосын хоёр, Монголын нэг, Хөх нуурын 1 хувилбар буй. Энэхүү хэв шинж нь бидний одоогоор олдоод байгаа бүх хувилбаруудтай давхцаж байдаг.

3. “Махчин хаанаа дарж болдгийн хөвгүүдээс ноён болгосон” гэх хэв шинж. ... Иймэрхүү хэв шинжээр яригддаг хувилбарын дотор зөвхөн буриадын хувилбарт яригддаг билээ.

4. “Торомын эхээр нь жинхэнэ эзнийг нь таньсан нь” гэх хэв шинж. ... Иймэрхүү хэв шинжээр яригддаг хувилбарын дотор зөвхөн Шинжааны хувилбар яригддаг билээ.

5. “Мухар үхэр барсыг мөргөж алсан нь” гэх хэв шинж. ... Иймэрхүү хэв шинжээр яригддаг хувилбарын дотор Ордосын 1 (А), Хөх нуурын 1 хувилбар буй.

6. “Уул довцогийн нууц” гэх хэв шинж. ... Иймэрхүү хэв шинжээр яригддаг хувилбарын дотор халимагийн 1, Шинжааны 1, Ордосын 1 (Б) Хөх нуурын 1, Монголын 1 хувилбар буй. Энэхүү хэв шинжийн үйл явдал нь их төлөвдөө уулын оройд нааддаг хөвгүүд зарга шүүхдээ онцгой мэргэн болдог тул хаан гайхаш алдаж, малтсанд онцгой нэгэн зүйлийн ширээ гарч ирдэг байна. Энэ нь мөн ч хүүхдүүд зарга шүүхдээ мэргэн байдгийн нууц нь ч ийнхүү үүндээ байдаг ажээ.

Дээр дурдсан газар орны монгол хувилбаруудад яригддаг “Уул оройгоос гаргасан ширээний тухай” мотивууд нь хоорондоо ялгаатай яригддаг нь энэхүү хэв шинжийн үлгэр нь уламжлалын явцдаа хэрхэн улиран хувьссан гэдгийг харуулж чадахуйц тодорхой жишээ болох юм. Жишээ нь халимаг хувилбарт “Найман хөлтэй цагаан өнгийн ширээ” гэж байхад буриадын хувилбарт иймэрхүү мотив байдаггүй. Шинжааны хувилбарт “32 хөлтэй модон ширээ” гэж яригдаж байхад Хөх нуурын хувилбарт “зандан ширээ” гэж яригддаг.

1928 онд Улаанбаатарт хэвлэгдсэн бичмэл эхэд “Нэгэн 32 гишгүүртэй, гишгүүр болгонд нь 32 модон хүний нэжгээд хатгасан алтан ширээ” гарч ирсэн гэж ярьж байхад 1937 онд хэвлэгдсэн Ордос хувилбарт “32 модон шаттай, шат бүр нь нэг модон хүүхэд хатгасан алтан ширээ” гарчээ гэж хоорондоо бараг адилаар яригдаж байдаг. Нэн сонирхолтой нь сүүлийн үед Ордосоос тэмдэглэгдэж авсан А хувилбарт энэхүү мотив нь яригддаггүй. Энэ нь сүүлийн үеийн хувилбаруудтай энэхүү мотив нь туйлын хувиралттай яригддаг болсон гэдэг нь харагдаж байна. Дээр бид нэгэнт энэхүү оршил

үлгэрийн хувилбарууд нь нийт ярианы хэв шинжээ үлгэрүүдээс нийлж бүтээсэн гэдгийг ойлгож мэдлээ. Дараа бид дэлхий нийтийн явган үлгэрийн АТ-ны эхлэлийн ангиллын аргыг үндэслэн эдгээр 6 хэв шинжийн үлгэрийн дотор аль нэг нь дэлхий нийтийн шинжтэй үлгэрийн хэв шинж болох, аль нь улс үндэстний онцлогтой хэв шинж болох, аль нь орон нутгийн онцлогтой үлгэрийн хэв шинж болохыг тус бүрд нь тодорхойлж, түүний нийтлэг буюу өвөрмөц онцлог шинжийг тодорхойлохыг хичээе.

Дэлхий нийтийн явган үлгэрийн ангиллын системээс үзэхэд энэхүү монгол оршил үлгэрийн хувилбаруудтай давтагдан яригддаг. “Шулам хөвгүүнийг лонхонд оруулан дарсан нь” гэх хэв шинж нь АТ-ны үлгэрийн хэв шинжийн ангилалд 926 А-гийн “Мэргэн шүүгч хүүхэд лонхон дахь шулам” гэх хэв шинжтэй адил хэв шинжийн үлгэр болох нь тодорхой байдаг. Тэр мөртөө энэхүү хэв шинж нь дэлхий нийтийн шинжтэй явган үлгэрийн хэв шинж болох нь тодорхой юм. Дараа нь бид АТ-ны ангиллын 926 А-гийн хэв шинжийн үлгэрийн үйл явдалтай дөхөм танилцая.

926 А. “Мэргэн шүүгч хүүхэд лонхон дахь шулам”

1. Нэг шулам айлын гоё бүсгүйг авахын төлөө түүний эр нөхөртэй нь адилхан дүрээр хувилан ирээд өнөөх бүсгүйг болиулдаг.

2. Бүсгүйн жинхэнэ залуу болон шулам хоёр өөр өөрийнхөө жинхэнэ залуу гэж маргах мөртөө өөр хүмүүс хэн ч хэд тэдний үнэн худлыг нь ялгаж чадахгүй.

3. Эцэстээ нэг шүүгч “Хаан буюу шүүгч болж тухлан суугч тоглон наадагч байсан бяцхан хүү, хар лам, зэрлэг туулай, чоно, тоть шувуу” тус заргыг шүүнэ.

4. Тэгээд шүүгчээс хэн хэрвээ жинхэнэ залуу бол энэ лонхонд орж чадна гэсэнд шулам тэр дор нь лонхонд үсэрч орно. Гэтэл бүсгүйн жинхэнэ залуу нь орж чадсангүй.

5. Шулам лонхонд ормогц лонхны амыг бөглөн шулмыг барьж авна. Тэгээд жинхэнэ залуу бүсгүйтэйгээ гэртээ харина.

Энэхүү хэв шинжийн үлгэр нь Болгар, Араб, Тува, Леван, Индиан, Непал, Дундад улс, Индонези, Япон, Египт, Судан зэрэг

улс үндэстний дунд уламжилж байдгаас үзэхэд энэ нь дэлхийн нийтийн шинжтэй үлгэрийн хэв шинж болох нь тодорхой юм. Үүнд нэгэн зүйлийг тодорхойлж хэлэхэд монгол газар орны хувилбарууд хүүхэд олон улсын хэцээн дэх хаувилбаруудын ялгаатай нэг зүйл гэвэл монгол хувилбаруудтай “хоёр ав адилхан төрсөн хөвгүүд аав ээж ба булаалддаг” бол олон улсын хувилбаруудад “ав адилхан төрсөн хоёр залуу нэгэн гоё бүсгүйг булаалддаг. Өөрөөр хэлбэл тухайн хэв шинжийн үлгэрт гардаг дүр нь адилгүй боловч түүнээр үйлдүүлэгч байгаа үйл ажиллагаа нь адил байдаг. Энэ нь яг В. Я. Проппын хэлсэн шигээр “үлгэрийн доторх цаг орон газар хүмүүсийн дүрийн хувиралттай байдаг боловч харин зохиолын дүрээр гүйцэтгүүлдэг үйл ажиллагаа үйл явдал нь хувиралтгүй” гэсэн үзэлтэй яг сайхан нийцэж очдог [Пропп 2006]. Энэ нь даруй ямар нэгэн хэв шинжийн үлгэрийн доторх цаг газар орон дүр нь адилгүй байдаг ч харин зохиолын дүрээр гүйцэтгүүлдэг үйл ажиллагаа нь адил бол тэр нь даруй нэг хэв шинжийн үлгэрт багтдаг гэснийг харуулж буй.

Монгол Арж борж хааны оршил үлгэрийн доторх “Молор эрдэнэ хэний болохыг шүүсэн нь” гэх хэв шинж нь дэлхий нийтийн явган үлгэрийн хэв шинжийн ангилалд байдаггүй боловч, харин Америкийн эрдэмтэн Диннай Тонны найруулан зохиосон “Дундад улсын явган үлгэрийн хэв шинжийн товъёог” (926 L) дугаар дахь “хуурмаг гэрч хүн” гэх хэв шинжид ойролцоо хэв шинжээр жагсаагаад оруулсан байдаг. Эхээс үзэхэд энэхүү хэвшинжийн үлгэр нь дэлхий нийтийн шинжтэй үлгэрийн хэв шинжид багтдаггүй боловч, дундад улсын явган үлгэрт байдаг юм байна. Иймээс бид энэхүү үлгэрийн хэв шинжийг улс үндэстний онцлогтой үлгэрийн хэв шинжид авч үзсэн байна. Дараа нь бид энэхүү хэв шинжийн үлгэрийн үйл явдалтай дөхөм танилцая.

926 L хуурмаг гэрч хөвгүүн

1. Нэг лам сүмээс нэг хэсэг алтыг хулгайлан авч нэг шинэ лам ирж тэр сүмийг хамаарах болсон гэнэ. Алт хулгайлсан лам шинэ ирсэн ламыг сүмийн алтыг хулгайлсан гэж заалдсанд бусад нар нь ч бүр түүнтэй тэмцэж заалджээ.

2. Нэгэн нутгаасаа салсан хүн нэг хэсэг эрдэнийн чулууг олоод танил нөхөддөө өгч ээждээ явуулжээ. Тэр нөхөд нь эрдэний чулууг ээжид нь өгөлгүй өөртөө авчээ. Үүнийг мэдээд заалдсанд тэр нөхөд нь хоёр ноёныг хуйвалдуулж, өөртөө гэрч болгожээ.

3. Хаталж эсвэл залуу ноёноос заалдагч болон заалдуулагч нар нь шүүх газар дуудаж, гэрч болох хүмүүсүүдийг хооронд нь хол зогсоож, тэдэнд нэг хэсэг шивэр өгөөд тэднээрээ алтан буюу эрдэнийн чулууны загварыг хийлгэжээ. Тэдгээр гэрч болох хүмүүс нь өнөөх алтан буюу эрдэнийн чулууг ерөөс үзсэнгүй тул тэд нарын хийсэн нэг ч хэлбэр нь хоорондоо бүр адилгүй болжээ. Худалч ноёноос тэд нарын хуурмаг гэрч болж байгааг илчилж эрдэнийн чулууг жинхэнэ эзэнд буцааж өгөхийг заргалджээ. Энэхүү хэв шинжийн үлгэрийн загвар нь БНХАУ-ын хэдэн үндэстний дунд (Монгол, Төвд, Хятад зэрэг) уламжилж байх төлөвтэй. Тийм мөртөө энэхүү хэв шинжийн үлгэр нь маш олон хувилбартайгаар уламжилж байх шинжтэй.

Монгол Арж борж хааны үлгэрийн оршил үлгэрийн доторх “Уул довцгийн нууц” гэх хэв шинжийг энэтхэгийн Ража Боожа хааны намтрын үлгэрийн хэв шинжтэй харьцуулж үзэхэд энэ хоёр хэв шинжийн үлгэр нь хоорондоо нэлээд ойролцоо байдаг тул бид үүнийг энэтхэг үлгэрийн дэд хэв шинж гэж үзсэн байна. Дараа нь бид энэтхэгийн Раажа Боожа хааны намтрыг 32 модон хүний үлгэрийн оршил үлгэрийн хэв шинжтэй танилцая.

Бид энэхүү оршил үлгэрүүд үндсэн агуулгыг нь үндэслэл тухайн үлгэрийн хэв шинжийн гарчгийг нь “32 хөлтэй эрдэнийн ширээний нууц” гэж гарчиглая.

32 хөлтэй эрдэнийн ширээний нууц

1. Эрт урьдын цагт Энэтхэг оронд Викрамадити хаан гэж байжээ. Хаан тэнгэрийн дагиныг хатан болгон авсанд Хурмаст дахин баясчээ. Хаан 32 хөлтэй, хөл бүрдээ модон хүнтэй ширээгээ соёрхжээ. Хаан нас барсны дараа түүний нялх хүү нь хаан суусан боловч ширээг эзлэх заяагүй гээд 32 хөлтэй эрдэнийн ширээг газар булжээ.

2. Олон он жил өнгөрсөн хойно Ража Боожа хааны үед нэг бярманы тарианы газарт нэг довтой юмсанж. Эзэн бярман нь тэр

дов дээр гарахдаа өгдөгч сайн сэтгэлтэй, буунгуут харамч муу сэтгэлтэй болдог гэнэ.

3. Раажаа Боожа хаан түүнийг мэдээд довыг малтсанд 32 модон хүнтэй эрдэнийн ширээ гарч гэнэ. Хаан тэр ширээнд суух гэтэл, ширээний хөлд байгаа 32 модон хүн хориглож, Викрамадити хааны суусан ширээ гэж 32 модон хүн тус бүр “Викрамадити хааны намтар”-аас өгүүлж, “Тийм буянтай сайн бол суу, үгүй бол битгий суу хэмээн ингээд 32 модон хүний үлгэр эхэлдэг байна”. Энэтхэгийн Раажа боожа хааны намтрын оршил үлгэрийн хэв шинж нь Монгол Арж Борж хааны үлгэрийн оршил үлгэрийн зарим нэг хувилбарт яригддаг юм байна. Гэхдээ нэлээд дээр үед тэмдэглэгдсэн хувилбаруудад яригддаг нь сонирхолтой санагдана. Жишээ нь 1928 онд Улаанбаатар хотноо хэвлэгдсэн монгол Арж Борж хааны намтарын бичмэл эхийн оршил үлгэрт иймэрхүү хэв шинж байдаг бөгөөд 1937 онд А. Мостэрын хэвлүүлсэн “Ордосын Арж Борж хааны намтар” үлгэрт иймэрхүү хэвшинж байдаг нь бидний санааг улам тодорхой болгож буй. Иймээс энэхүү хэв шинж нь энэтхэг үлгэрийн уул хэв шинж гэдэг нь мэдэгдэж буй. Харин сүүлийн үеийн хувилбаруудад нэлээд хувиралттайгаар яригддаг байна. Учир нь монголчууд иймэрхүү үлгэрийн хэв шинж байдаггүй тул аль болохоор өөрийн үлгэрийн хэв намбадаа зохицуулан ярьдаг юм байна. Жишээ нь: халимагийн А хувилбарт “тэр хөвгүүдийн өдөр болгон наадаж байдаг уулын толгойг малтсанд хөлтэй цагаан өнгөтэй ширээ гарчирж гэнэ. Арж Борж хаан тэр ширээн дээр сууснаас их ой ухаантай сайн заргач хаан болж гэнэ” гэж яригддаг бол буриадын А хувилбарт иймэрхүү мотив байдаггүй [Халимаг туульс 1968: 116].

Шинжааны хувилбарт Арж Борж хаан гайхаш алдаж, хүүхдүүдийн нааддаг уул оройг малтсанд доороос нь 32 хөлтэй модон ширээ гарч Арж Борж хаанд энэ ширээ болвол Бигармижид хааны суух ширээ мөн гээд нисэн гарахад, хаан цавчсанд нэг хөл нь унаж иржээ [Ринчиндорж, Дамринжав 1988] гэж иймэрхүү өгүүлдэг бол Хөх нуурын хувилбарт “Хаан үүнийг сонсоод гайхаш алдаж, хүүхдүүдийн нааддаг довцогийг малтсанд нэг зандан ширээ гарч, хаан тэр ширээнд сууснаас хойш гарсан заргыг зөвөөр

шийддэг болсон гэнэ” гэж зандан ширээний нууцыг тайлбарласан маягаар яригддаг [Зандан ширээ 1990: 441–442]. Харин сүүлийн үед тэмдэглэгдсэн Ордосын А хувилбарт иймэрхүү мотив байдаггүй. Дээрх задлалтаас бид монгол Арж Борж хааны намтрын оршил үлгэр нь дэлхий нийтийн явган үлгэрийн хэв шинж болох “Мэргэн шүүгч хүүхдүүд лонхон дахь шулмас” болон улс үндэстний явган үлгэрийн хэв шинж “Хуурмаг гэрч хүн” энэтхэг үлгэрийн хэв шинж 32 хөлтэй эрдэнийн ширээний нууц зэрэг хэв шинжээс нийлүүлж бүтсэн гэдгийг ойлгож мэдсэн байна.

Үүнээс гадна энэхүү оршил үлгэрүүд доторх “Махчин хаанаа дарж болдгийг хөвгүүдээс ноён болгосон нь”, “Торомын эхээр жинхэнэ эзнийг нь танисан нь”, “Мухар үхэр барсыг мөргөж алсан нь” гэх 3 хэв шинжийн үлгэр нь дэлхий нийтийн болон үлгэр бусад улс үндэстний явган үлгэрт илэрхий хэв шинжүүд байдаггүй мөртөө монголчуудын зарим нэг онцгой газар орноор яригддаг тул бид үүнийг газар орны онцлог бүхий явган үлгэрийн хэв шинж гэж үзсэн байна. Эдгээр хэв шинжийн үлгэрүүд нь монголчууд өөрийн ахуй амьдралдаа зохицуулан шинээр зохиосон үлгэр болох нь тодорхой юм.

Бид дээрх задлалтаас дараах тохиолдлыг олж болох байлтай. Юу гэвэл монгол Арж Борж хааны намтрын оршил үлгэр нь уламжлалын явцдаа дараах үлгэрүүдийн хэв шинжийг онцлогуудаас нийлж бүтсэн байдаг. Даруй дэлхий нийтийн шинжтэй явган үлгэрийн хэв шинж монгол үндэстний онцлогтой үлгэрүүдийн хэв шинж орон нутгийн онцлог бүхий үлгэрийн хэв шинжүүдээс нийлэлдэн бүтсэн нийлмэл бүтэцтэй үлгэр болох юм. Дээрх харьцууллаас монгол Арж Борж хааны намтарыг энэтхэгийн Арж Борж хааны намтраас шууд орчуулсан зохиол гэхэд туйлын хүчиртэй гэдгийг үзэн гаргаж болно.

Зохиолын баатрын нэр болон зарим нэгэн үйл явдал нь хэдийгээр энэтхэг хувилбараас гаралтай боловч, олонх үйл явдлын хэв шинж мотивууд нь монголчуудын дунд уламжлахдаа шинээр зохиогдсон монгол үлгэр болох нь тодорхой юм. Нэн тодорхойлж хэлэхэд энэхүү оршил үлгэр нь энэтхэг үлгэрийн хэв шинж мотивоос гадна дэлхий нийтийн явган үлгэрийн хэв шинж улс үндэстний онцлог

бүхий явган үлгэрийн хэв шинжээс нийлэлдэн бүтсэн байдаг. Иймээс ямар нэгэн улс үндэстний явган үлгэр нь өөр бусад улс үндэстний дунд уламжлагдахдаа өөрий хэв шинжээ ямар нэгэн хэмжээнд хадгалахын зэрэгцээ тухайн улс үндэстнийхээ үлгэрийн үйл явдалтай зохицож, улиран хувьсдаг гэдгийг дээрх жишээнээс тодорхой ойлгож болох юм.

Миний сэдвийн жолоодогч Цэцэнмөнх “Явган үлгэр нь анхлан судлагдсан тэр цаг үеэс эхлээд хүмүүст нэгэн зүйлийг ойлгуулагдсан юм. Юу гэвэл зөвхөн үлгэр нь дэлхий нийтийн хэвцэнд улс үндэстний дунд нийтмэл уламжилж байхаар барахгүй тооны талаар ч маш олон байдаг” гэснийг ойлгож мөн үүний зэрэгцээ адил нэг үлгэр нь маш олон адил бусын газар орон буюу адил бусын улс үндэстнүүдийн дунд уламжилж байдгийг ч ойлгож мэдсэн байна. Үүний дундаас эрдэмтэд явган үлгэрийн уламжлалын түгээмэл нэг онцлогийг сурч мэдсэн юм. Энэ нь даруй явган үлгэрийн тоо нь хэдийгээр олон боловч, түүний доторх олонх үйл явдал нь ямар нэгэн адил үйл явдлын хувилбарууд байдаг гэснийг олж мэдсэн байна. Энэ тухай зарим нэг улсын бүрэн бус бүртгэлийг үндэслэвэл нэг үндэстний дунд уламжилж байгаа үлгэрийн гурвны нэгээс дээших нь олон улс үндэстний шинжтэй буюу цаашилбал дэлхий нийтийн шинжтэй байдаг» гэж тодорхойлжээ [Цэцэнмөнх, Сарантуяа 2010]. Энэ нь юуг харуулж байна гэвэл явган үлгэрийн тоо нь ганцааргүй олон байдаг боловч үлгэрийн үйл явдлын хэв шинж нь харьцангуй ганцаар байдаг.

Иймээс олон улсын явган үлгэрийг судлагч эрдэмтэд дэлхий нийтийн нийтлэг шинжтэй явган үлгэрийн үйл явдлын хэв шинжийг ерөнхийдөө 700–800-ийн хооронд харьяалж гаргасан байдаг. Гэхдээ үүнээс нэн олон байх нь зайлшгүй хэрэг. Учир нь харьяалал бол одооны эрдэмтдийн гарт байгаа хязгаартай эх хэрэглэгдэхүүндээ суурилж харьяалагдсан дутуу юм. Тэгэхдээ дэлхийн улс үндэстний явган үлгэрийн хэв шинжид дараах хэдэн талын онцлогтой байдлын тухай эрх биш тодорхой ойлголттой байх хэрэгтэй.

1. Улс үндэстний явган үлгэрийн үйл явдалд дэлхий нийтийн олон улсын чанартай нийтлэг онцлог бүхий хэв шинж болон

мотивууд гэж байдаг. Иймэрхүү нийтлэг бүхий үлгэрийн хэв шинж нь дэлхий нийтийн явган үлгэрийн бараг 3,2% шахамыг эзэлдэг. АТ-ны ангиллын системд энэхүү нийтлэг бүхий үлгэрийн хэв шинжийн шууд оруулан жагсааж өгдөг. Иймэрхүү нийтлэг бүхий үлгэрийн хэв шинжүүдийг хэн нь хэнээсээ жишээлэлээ гэж судлахын арга байдаггүй.

2. Явган үлгэрийн үйл явдалд улс үндэстний нийтлэг онцлог бүхий хэв шинж буюу мотивууд гэж байдаг. Энэ нь даруй ямар нэгэн улс буюу үндэстний хэвцээнд уламжилж байгаа үлгэрийн хэв шинжүүдийг заана. Иймэрхүү онцлог бүхий үлгэрийн хэв шинж нь улс үндэстний явган үлгэрийн бараг 3,1%-ийг эзэлнэ. АТ-ны ангиллын системд энэхүү онцлог бүхий үлгэрийн хэв шинжүүдийг барагтаа дэлхий нийтийн онцлог бүхий үлгэрийн дэд хэв шинж буюу ойролцоо хэв шинжээр шийдвэрлэж өгдөг.

3. Явган үлгэрийн үйл явдалд дээр дурьдсан онцлог бүхий үлгэрийн хэв шинжүүд байхаас гадна орон нутгийн буюу газар нутгийн нийтлэг онцлогтой үлгэрийн хэв шинж буюу мотивууд гэж байдаг. Дэлхий нийтийн АТ-ын ангиллын системд иймэрхүү онцлогтой үлгэрийн хэв шинжүүдийг оруулан жагсааж өгдөггүй буюу тусд нь систем зохиож жагсааж өгдөг зуршилтай гэж маш оновчтой үзэлтийг дурдсан байдаг.

Бидний нэг энд хэлэлцэж байгаа монгол Арж Борж хааны намтар үлгэрийн оршил үлгэр бол яг дээр дурдсан 3 онцлог бүхий үлгэрийн хэв шинжүүдээс нийлүүлж бүтсэн үлгэр гэдэг нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл олон улсын нийтлэг шинжтэй үлгэрийн хэв шинж болон улс үндэстний онцлогтой үлгэрийн хэв шинж, нэн цаашдаа орон нутгийн онцлогтой үлгэрийн хэв шинжүүдээс нийлж бүтсэн үлгэр болох юм.

Бид дээрх хувилбаруудын зарим нэг мотивын харьцууллаас нэг зүйлийг ойлгож болох байлтай. Юу гэвэл 1930-аад оноос өмнө тэмдэглэгдсэн хувилбарууд нь энэтхэг үлгэрийн хэв шинжийн намбын ямар нэгэн хэмжээтэй хадгалж байхад түүнээс сүүлээр тэмдэглэгдсэн хувилбарууд нь энэтхэг үлгэрийн хэв шинжээс шал өөр болж, монголчлогдон монгол үлгэр болж улиран хувиссан явдал нь үлгэрийн уламжлалын чанад нэг ёс учрыг тодорхойлж

буй. Юу гэвэл ямар нэгэн харь улс үндэстний үлгэр нь нөгөө нэг улс үндэстний дунд (дундах уламжлал нь) уламжлах түүх нь урт болох тусмаа дараа нь уул хэв шинжээсээ улам холдож, тухайн улс үндэстнийхээ соёлын орчин ахуйдаа бүрмөсөн уусч харь үндэстний үлгэр гэхийн аргагүй болтол улиран хувисдаг. Ийнхүү нэгэн жишээ нь монгол Арж Борж хааны намтар болох юм.

Ш. “Арж борж хааны намтар”-ын уламжлал хувьслын асуудалд

Энэтхэгийн “Арж Борж хааны намтар” нь Монгол оронд амаар уламжлахдаа танигдахын аргагүй болтол улиран хувьссан гэдгийг дараах хэдэн жишээгээр тодруулж болох шиг санагдана:

Монгол “Арж Борж хааны намтар”-ын оршил үлгэрийн эл хувилбаруудаас үзэхэд Оросын Буриад, Халимаг, Дундад улсын Шиньжан, Хөх нуурын хувилбарууд жич Өвөр Монголын Ордосын сүүлийн үеийн хувилбар зэрэг нь ихээхэн хувиралттай болсон нь тодорхой мэдэгдэж байдаг. Жишээлбэл, Оросын Буриадын хувилбарт “Махчин хаанаа дарж, Болдогийн хөвгүүдээс ноён болсон нь” гэх хэв шинжийн үлгэр нэмэгдсэн байхад Шинжааны хувилбарт “Торомын эхээр нь жинхэнэ эзнийг нь таньсан нь” гэх хэв шинжийн үлгэр нэмэгдсэнээс гадна, Хөх нуур болон Ордосын сүүлийн үеийн хувилбарт “Мухар үхэр барсыг нь мөргөж алсан нь” гэх хэв шинжийн үлгэрүүд нэмэгдсэнээс бүр ч монгол амьдралтай, монголжуун үлгэр болсон нь тодорхой байдаг. Цаашилбал, Халимагийн хувилбарт “Таван хошуу малтай Арж Борж хаан гэдэг нэгэн хаан байжээ” гэж яригддаг бөгөөд олонх монгол хувилбарт Арж Борж хааныг малжих орны хаан носноор ярьдаг нь тухайн үлгэрийн монголжсоны нэгэн тодорхой жишээ болох юм [Халимаг туульс 1968: 113]. Нэн сонирхолтой нь Хөх нуурын хувилбарт Арж Борж гэдэг энэтхэг нэртэй хаан ч гардаггүй мөртөө цул малжих амьдралтай монголжуун үлгэр болсноос үзэхэд Хөхнуур нь энэхүү энэтхэг үлгэрийн монголжсоны эх нутаг байж болзошгүй.

Дээрх жишээнээс үзэхэд, монгол “Арж Борж хааны намтар”-ын оршил үлгэр нь монголчуудын дунд яригдах тусмаа бүр

танигдахын аргагүй монгол үлгэр болсон байдаг. Үүнд Халимагийн нэгэн хувилбар болох — “Долоон настай хөвгүүн” гэх үлгэрээр жишээлэхэд бүр шал монгол үлгэр болсон гэдэг нь тодорхой байдаг [Халимаг туульс 1990]. Дараа нь бид энэхүү үлгэрийн үйл явдалтай дөхөм танилцъя. Тухайн үлгэрийн үйл явдлын тойм нь:

I. Хязгаар цагт нэг орон нутгийн хааны заргач түшмэл байжээ.

II. Нэг удаа хаанд гурван зүйлийн зарга орж иржээ.

1. Өвчтэй байсан хүн адууны хөлд үхсэн эсэхийг шүүх.

2. Нуурт суусан нугасыг хоёр анчны аль нь урьдаар буудсаныг шүүх.

3. Ав адилхан төрсөн хоёр хөвгүүнийг аль нь жинхэнэ хөвгүүн болохыг ялган таних.

III. Ингээд хааны заргач түшмэл нь энхүү гурван заргыг шүүж чадахгүй зовж байхад долоон настай хөвгүүн нь аавдаа арга ухаан зааж заргыг зөвөөр шүүсэн юм гэнэ.

Энэхүү хувилбар нь “Арж Борж хааны үлгэр”-ийн уул хэв шинжээсээ нэлээд холдсон нь тодорхой юм. Гэхдээ тухайн үлгэрийн уул хэв шинжийн онцлогоо ямар нэгэн хэмжээнд хадгалж байгаа нь ч тодорхой юм. Өөрөөр хэлбэл, уулын үлгэрийн үйл явдлын суурин дээр шинээр зохиогдсон үлгэр болох нь тодорхой юм. Жишээлбэл уул үлгэрт Арж Борж хаан нь заргач хаан байсан бол энэ хувилбарт Арж Борж хаан нь нэгэн орон нутгийн хааны заргач түшмэлээр яригддаг. Уулын үлгэрт Арж Борж хаан нь заргыг буруугаар шүүдэг бол энэ хувилбарт заргач түшмэл нь заргыг чухам яаж шүүх аргаа ч олдоггүй байна. Уулын үлгэрт Арж Борж хааны буруу шүүсэн заргыг довцог дээр нааддаг долоон хөвгүүнээс зөвөөр шүүж чаддаг бол энэ хувилбарт заргач түшмэлийн долоон настай хөвгүүн нь аавдаа арга ухаан зааж заргыг зөвөөр шүүж чаддаг байна. Өөрөөр хэлбэл, долоон хөвгүүн нь долоон настай хөвгүүн болсон байна. Эдгээр зүйл дээр хувиралттай болсон боловч үлгэрийн үйл явдлын уул хэв шинж нь ерөөс хувиралт гарсангүй. Энэ хувилбарт долоон настай хөвгүүнд энэхүү заргыг шүүх аргыг хэн ч зааж өгдөггүй бол харин уул үлгэрт хүүхдүүдийн зарга шүүх аргыг довцогт булгатай байдаг Бигармижид хааны ширээ далдаас тусалдаг.

Дахин нэг жишээг дурдахад, бидний дээр дурдсан Шинжааны “Арж Борж хан” гэдэг хувилбарын эцэст ийм нэгэн өгүүлэмж яригддаг. “Арж Борж хан тэрхүү уул орой малтсанд доороос нь нэг гучин хоёр хөлтэй модон ширээ гарч иржээ. Тэрхүү ширээ гарч ирээд Арж Борж ханд, “Энэ ширээ бол Бигармижид хааны суух ширээ мөн, Арж Борж хааны суух ширээ биш” гэж хэлээд нисэн гарчээ. Тэгэхэд Арж Борж хан цавчсан чинь нэг хэлийг нь унагажээ. Энэхүү хэлийг нь нэг баян аваад үүдэндээ шаанцаг тавьсан гэнэ. Тэгээд энэ шаанцаг нь богд эзэн хан, бүдүүн Баогийн Зондоо болон баяны хөвгүүнд цугт нь тусалсан гэнэ” гэж өгүүлдэг. Энэхүү өгүүлэмжийн суурин дээр цаашид “Бүдүүн Баогийн Зондоо” гэх үлгэр зохиогдсон байдаг. бид тус үлгэрийн үндсэн агуулгыг нь үндэслэн утхайн үлгэрийн хэв шинжийн гарчгийг нь “Баян айлын үүд шаанцгийн нууц” гэж гарчигласан байна.

Баян айлын үүд шаанцгийн нууц

Тухайн хэв шинжийн үлгэрийн үйл явдлын тойм нь:

I. Эрт урьд цагт хэчнээн идэж уусан ч гэдэс нь цадахгүй хүн байж гэнэ. Тэр нэг өдөр нэг мэдлэгтэнд хүрээд: “Би идэж цадах өдөр байна уу, үгүй юу?” гэсэнд “Чи удалгүй эзэн хааны зондоо сууна. Тэр үед үргэлж цадна” гэж хэлжээ.

II. Энэхүү бүдүүн Баогийн зондоо суусан хүн нэг хоногоос өнгөрөхгүйгээр үхдэг байжээ.

III. Энэ зондоо суух хүн Бээжин орохоор явж байгаад замдаа нэг айлынд хүрэхэд тэр баян айлын хөвгүүн нь үхэх гэж байжээ.

IV. Тэр зондоо суух хүн шөнө нь өвчинтэй хөвгүүний хажууд унтаж байгаад үүдний шаанцагаас хөвгүүний өвчин нь шулам эмгэний уршгаас болж байна гэдгийг мэдээд маргааш нь шулам эмгэнийг дарж, хөвгүүнийг аварсанд баян айлын эзэн ихэд баярлаж, ачлалын хариуд “Үүдний шаанцаг”-аа өгчээ.

V. Ингээд зондоо суух хүн алсын замдаа үүдэн шаанцагаас зондоо суусан хүн бүхэн юунд ч үхээл байдгийг ойлгож мэдээд ханы шулам хатныг нь цавчиж алсанд зондоо суусан хүмүүс үхэхгүй болж гэнэ.

VI. Ингээд тэрхүү шаанцгийн үгээр бүдүүн Баогийн зондоо үхэхгүй болсон ба хааны хортныг дарсан тул энэхүү шаанцаг нь

Арж Борж хааны үлгэрт гарах гучин хоёр модон хөлтэй ширээний нэг хөл нь болсон гэнэ. (Тодорхойлох нь, энд илэрхий буруу болсон нь мэдэгдэж буй).

Энэхүү хэв шинжийн үлгэр нь Шинжааны “Арж Борж хан” гэх хувилбарын суурин дээр цааш улиран хувьссан гэдэг нь илэрхий юм. Юу гэвэл, дээрх хувилбарт нь “Гучин хоёр хөлтэй Бигармижид хааны ширээ далдаас хүүхдүүдийн оюун ухааныг цэцэн сэргэлэн болгодог байсан” бол энэхүү хувилбар нь “Гучин хоёр модон хөлтэй Бигармижид хааны ширээний нэг хөл нь баян айлын үүдний шаанцаг болж бод биеэрээ хаан ноён болон эзэн хааны зондоо суух хүн жич баян айлын хөвгүүнийг авардаг байна”. Учир юун гэвэл, Бигармижид хааны суудаг гучин хоёр хөлтэй ширээ нь энгийн хүний суух ширээ биш, харин туйлын ид шидтэй ширээ гэдэг санааг харуулах гэсэндээ байдаг.

Энэ нь мөн ч энэтхэг үлгэрийн уулын мотив суурин дээр монголчуудын ургуулан зохиосон шинэ нэгэн хэв шинжийн үлгэр болох юм.

Дүгнэлт

Бид дээрх задлалтаас дараах дүгнэлтэд хүрч болох шиг санагдана.

Нэг. Ямар нэгэн үлгэр нь өөр бусад улс үндэстний дунд уламжлахдаа юуны урьд тухайн улс үндэстнийхээ соёл зан заншилтайгаа зохицуулан хүлээн авдаг гэснийг дээрх жишээнээс тодорхой ойлгож болох юм. Нэн тодруулж хэлэхэд ямар нэгэн үлгэрчээс харь үндэстний үлгэрийг уламжлахдаа юуны урьд өөрийн амьдралын орчин ахуй, соёлтойгоо зохицуулан зарим нэгэн мотивыг нь өөрчлөх буюу тухайн үлгэрийн мотивын суурин дээр дахин шинэ нэгэн мотивыг нэмэн зохиож шинэ нэгэн хэв шинжийн үлгэрийг буй болгодог. Энэхүү шинэ нэгэн хэв шинжийн үлгэр нь тухайн үндэстний өвөрмөц хэв шинж болж цааш уламжлагдахдаа өөр нэгэн үндэстний үлгэрийн өвөрмөц хэв шинжийн суурь нь болдог.

Хоёр. Ямар нэгэн үлгэрийн хэв шинж нь өөр нэгэн үлгэрийн мотив буюу хэв шинжтэйгээ нийлээд өөр нэгэн үлгэрийн хэв

шинжийг буй болгодог. Үүний нэг тодорхой болон улс үндэстний онцлог бүхий явган үлгэрийн хэв шинжүүдээс нийлж бүтсэн байдаг. Иймээс ямар нэгэн улс үндэстний үлгэр нь өөр бусад улс үндэстний дунд уламжлахдаа өөрийн уулын хэв шинжээ зохих хэмжээнд хадгалахын зэрэгцээ тухайн улс үндэстнийхээ үлгэрийн үйл явдалтайгаа нийлэлдэн зохицож улиран хувьсдаг гэдгийг дээрх харьцууллаас тодорхой ойлгож болох юм.

Гурав. Ямар нэгэн үлгэрийн онцгой мотив нь шинэ нэгэн үлгэрийн хэв шинжийг бий болгодог. Тухайлбал, Шинжааны хувилбарт “Гучин хоёр хөлтэй ширээ” гэдэг онцгой мотивын суурин дээр “Шаанцаг”-ийн үлгэр бий болсон байх жишээтэй.

Дөрөв. Зарим үест хоёр хэв шинжийн үлгэр нь нэг л хэв шинжийн үлгэрээр яригддаг үзэгдэл бий. Тухайлбал, Хөх нуурын хувилбарт “Эрдэнийг олж ямар нэгэн залууд өгч гэртээ явуулах буюу ав адилхан төрсөн хоёр хөвгүүн аав ээжээ булаалдах» гэх хоёр хэв шинж нь нэг л хэв шинжийн үлгэрээр яригддаг нь үүний тодорхой нэгэн жишээ болох юм.

Номзүй

- Ванжинжав 2005 — Ван, Ванжинжав. Ордос ардын аман зохиолын билгийн сан оршвой. Хуххот: Өвөр Монголын өөртөө засах орны сонин мэдээ хэвлэлийн товчооны, 2005.
- Веселовский 1930 — *Веселовский А. Н.* Собрание сочинений. Т. 8. М.; Л.: Изд-во Акад. наук СССР, 1930. 606 с.
- Дамдинсүрэн, Чанту 1983 — *Дамдинсүрэн Ц., Чанту В.* Монголын уран зохиолын тойм (дээд). Хуххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1983.
- Зандан ширээ 1990 — Зандан ширээ. Хайсигийн явган үлгэр. Хятад довтоод хэвлэл, 1990.
- Лауфер 1927 — *Лауфер Б.* Очерк монгольской литературы. Л.: Ленингр. вост. инст-т, 1927. 95 с.
- Мостэр 1982 — *Мостэр А.* Арж Борж хаан (доорд дэвтэр). Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 1982.
- Мөнх, Бат 1998 — *Мөнх До., Бат Ч.* Анхны хайлт ойрд утга зохиолын судалгааны өгүүлүүд. Үрмч: Шиньжаны ардын хэвлэлийн хороо, 1998.

- Пропп 2006 — *Пропп В. Я.* Үлгэрийн хэлбэр зүй. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 2006.
- Ринчиндорж, Дамринжав 1988 — *Ринчиндорж Ж., Дамринжав Б.* Зургаадай мэргэн (Ил Тарвагатайн монгол үлгэр). Хуххот: Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо, 1988.
- Төмөр, Алтан, Соном, Цагаанхүүхэн 2009 — *Төмөр, Алтан, Соном, Цагаанхүүхэн Б.* Морин цагаан сувд. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 2009.
- Халимаг туульс 1968 — Халимаг туульс. 4 боть. Элст: Халимаг хэвлэлийн хороо, 1968.
- Цэцэнмөнх, Сарантуяа 2010 — *Цэцэнмөнх, Сарантуяа.* Монгол ардын явган үлгэрийн хэв шинжийн судалгааны удиртгал, Хуххот: Үндэстний хэвлэлийн хороо, 2010.
- Халимаг туульс 1990 — Халимаг туульс. Үрмч: Шиньжаны ардын хэвлэлийн хороо, 1990.